



ХӨХ ГАН ХК

Улаанбаатар-36, Хан-Уул дүүрэг, Чингисийн
өргөн чөлөө, 15-р хороо, 50-р байр, ш/х-278

Утас: 976-70072777, Факс: 976-70071777,

И-мэйл: beren@mongol.net

Вэбсайт: www.beren.mn

2020.04.07 № 20/22.

танай _____-ны № _____-т

Хүсэлт гаргах тухай

Манай компани Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг энэ оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн 14цагт хийхээр төлөвлөж холбогдох шийдвэрийг танай байгууллагад хүргүүлсэн билээ.

Улсын онцгой комиссын 2020оны 03дугаар сарын 20-ны өдрийн шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаа цахимаар санал хураах ажиллагааг зохион байгуулахаар болсон тул Хөрөнгийн биржийн сайтад байршуулсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын зард өөрчлөлт оруулж өгч бидний ажилд туслана уу.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг шинэчлэн хүргүүлэв /Хавсралт-1 хуудас/

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ -  /Д.МӨНХБАЗАР/



ХӨХ ГАН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 102 тоот тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан Хөх ган ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14:00 цагт** цахимаар явагдах болсныг мэдэгдэж байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Хөх ган ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох;
5. Компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай;
6. ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр: **2020 оны 04 сарын 02-ны өдөр**

Хувьцаа эзэмшигчид харилцах ҮЦК-иараа дамжуулан саналаа өгөх боломжтой бөгөөд саналын хуудсаар санал авах хугацаа 2020 оны 04 сарын 29-ны 17 цагт дуусна.

Хувьцаа эзэмшигчид хурлын материал болон хуралд цахим хэлбэрээр хэрхэн оролцож санал өгөх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хурал зохион байгуулах комисс болон дараах и-мэйл хаягаар тодруулна уу.

Хурал зохион байгуулах комисс: 99075698, 70072777 , 94092846

И-мэйл: erkhemzaya@bdsec.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС